



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/04/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2023 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.09.25 № 813
танай _____ -ны № _____ -т

ГУРВАНТЭС СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.ГАНГАМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гурвантэс сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Гурвантэс сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 177,294.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 24 дугаар зүйлийн 24.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6, 8 дугаар зүйлийн 8.1, 15 дугаар зүйлийн 15.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд сумын ИТХ-ын 2023 оны 13/07 дугаар тогтоолоор 8 хөтөлбөр, арга хэмжээнд 326,280.0 мянган төгрөг зарцуулахаар батлуулан, гүйцэтгэлээр 326,280.0 мянган төгрөг зарцуулсан байна.

016020550

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн орлого 25,421,596.5 мянган төгрөг төсөвт төвлөрүүлэхээс 36,239,164.4 мянган төгрөг төвлөрүүлж 10,817,567.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна

Бусад асуудлын хэсэг

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 91 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 92.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,082,222.54	8,605,979.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,373,034.56	5,943,424.16
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	1,373,034.56	5,943,424.16
31210	Төгрөг	1,373,034.56	5,943,424.16
31211	Төрийн сангийн харилцах	1,266,725.55	5,705,866.33
31213	Арилжааны банк дахь харилцах	106,309.01	237,557.82
33	АВЛАГА	301,672.58	381,734.83
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,653.55	1,042.63
33401	Дансны авлага /ТӨҮГ/	10,718.32	24,685.81
33500	Бусад авлага	289,300.72	356,006.39
33510	Байгууллагаас авах авлага	41,822.91	56,670.66
33520	Хувь хүмүүсээс авах авлага	247,477.80	299,335.73
35	БАРАА МАТЕРИАЛ	433,135.21	931,047.30
35100	Түүхий эд материал	10,410.93	441,854.57
35110	Тусгай зориулалттай материал	912.00	434,412.38
35130	Эм боох материал	9,498.93	7,442.19
35300	Бэлэн бүтээгдэхүүн	304.22	-
35400	Хангамжийн материал	327,369.06	395,429.93
35410	Бичиг хэргийн материал	3,986.73	5,039.78
35420	Аж ахуйн материал	65,055.17	69,702.40
35430	Сэлбэг хэрэгсэл	24,193.03	30,650.07
35440	Түлш, шатах тослох материал	21,728.15	20,762.33
35470	Бусад хангамжийн материал	212,405.99	269,275.35
35600	Мал амьтад	95,051.00	93,762.80
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	974,380.19	1,349,773.16
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	974,380.19	1,349,773.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,668,066.35	16,073,708.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,668,066.35	16,073,708.01
39200	Биет хөрөнгө	13,481,771.51	15,889,725.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,532,006.85	15,462,675.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,557,114.41)	(4,341,761.46)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	622,497.70	708,921.28
39204	Хуримтлагдсан элэгдэл	(288,042.85)	(364,283.02)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,150,161.77	1,614,668.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	(357,446.76)	(421,706.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	230,951.49	309,646.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(118,530.67)	(136,601.24)
39209	Зам, гүүрний байгууламж	2,239,620.03	2,952,088.60
39210	Хуримтлагдсан элэгдэл	(207,532.63)	(404,432.78)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	25,000.00	25,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	292,708.08	599,906.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	(82,507.08)	(114,396.21)
39300	Биет бус хөрөнгө	186,294.85	183,982.77
39301	Программ хангамж	10,502.50	10,411.25
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,140.25)	(6,361.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	179,932.60	179,932.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,750,288.89	24,679,687.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,263,717.85	5,079,955.28
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	481,711.84	714,616.28
41300	Өглөг	481,187.99	713,990.38
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	666.75	347.41
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	49,000.00	195,815.90

41360	Бусад өглөг	431,521.24	517,827.08
41361	Байгууллагад төлөх өглөг	408,122.81	474,155.28
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	20,137.25	18,663.39
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	2,195.07	14,972.50
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	1,066.10	10,035.91
41400	Урьдчилж орсон орлого	523.85	625.90
41440	Бусад урьдчилж орсон орлого	523.85	625.90
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,782,006.02	4,365,339.00
42200	Урт хугацаат зээл	2,782,006.02	4,365,339.00
42210	Төгрөг	2,782,006.02	4,365,339.00
42241	Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	2,782,006.02	4,365,339.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,486,571.04	19,599,732.17
51	Засгийн газрын хувь оролцоо	13,486,571.04	19,599,732.17
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,186,916.70	6,186,916.70
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	6,186,916.70	6,186,916.70
51200	Хуримтлагдсан үр дүн	6,647,243.15	12,760,404.28
51210	Өмнөх үеийн үр дүн	12,772,728.51	6,683,191.14
51220	Тайлант үеийн үр дүн	(6,125,485.36)	6,077,213.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	652,411.19	652,411.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,750,288.89	24,679,687.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	17,937,845.58	41,531,982.58
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,246,834.54	36,159,943.68
110	Орлогын албан татвар	3,427,738.56	30,753,052.64
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,452,711.83	30,798,044.51
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	3,270,058.61	10,286,854.61
110002	Үйл ажиллагааны орлого	21,650.89	18,115.09
110003	Хөрөнгийн орлого	-	107,372.04
110004	Хөрөнгө борлуулсны орлого	34,910.19	16,476.00
110008	Шууд бус орлого	126,092.14	20,369,226.78
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(24,973.26)	(44,991.87)
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(24,973.26)	(44,991.87)
113	Хөрөнгийн албан татвар	2,147,950.90	2,157,461.77
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,121,979.69	2,131,449.52
113002	Бууны албан татвар	3,739.00	4,565.20
113004	Малд ногдуулах албан татвар	22,232.21	21,447.05
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,671,145.08	3,249,429.27
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	132,582.35	234,661.95
118001	Улсын тэмдэгтийн хураамж	23,581.81	20,325.50
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	78,111.74	150,168.95
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	30,888.80	64,167.50
1181	Газрын төлбөр	2,527,999.31	2,998,329.98
118101	Газрын төлбөр	2,527,999.31	2,998,329.98
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	10,563.41	16,437.35
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	10,563.41	16,437.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,365,542.67	2,644,014.51
120	Нийтлэг татварын бус орлого	3,365,542.67	2,644,014.51
120002	Хүүгийн орлого	107,641.64	-
120003	Торгуулийн орлого	71,991.65	798,092.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,445.49	119,066.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500.00	-

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,183.59	119,066.18
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,761.90	-
120009	Бусад орлого	256,361.52	337,674.66
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	1,047,447.42	1,060,893.32
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	621,110.27	770,516.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,355,475.22	844,062.81
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	95,290.00	254,740.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,325,468.36	2,728,024.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,343,405.73	2,002,720.20
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1,343,405.73	2,002,720.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	712,499.96	725,304.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	7,788.24
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	696,043.85	557,367.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,322.01	12,411.23
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,134.10	147,737.26
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,269,562.68	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,638,018.00	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	631,544.68	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	14,881,521.45	35,448,861.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,881,521.45	35,448,861.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,347,667.16	7,542,918.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,076.36	758,473.00
210101	Үндсэн цалин	374,797.04	458,513.42
210102	Нэмэгдэл	49,521.39	199,567.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,686.00	29,385.50
210104	Урамшуулал	6,071.93	71,006.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,655.07	91,680.37
210201	Тэтгэврийн даатгал	37,121.20	64,056.70
210202	Тэтгэмжийн даатгал	4,429.29	7,502.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,584.45	5,940.34
210204	Ажилгүйдлийн даатгал	842.72	1,279.13
210205	Эрүүл мэндийн даатгал	8,677.41	12,901.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	457,700.71	132,308.37
210301	Гэрэл, цахилгаан	28,599.69	17,565.30
210302	Түлш, халаалт	398,401.92	112,225.90
210303	Цэвэр, бохир ус	30,699.10	2,517.17
2104	Хангамж, бараа материалын зардал	1,579,680.31	1,543,938.04
210401	Бичиг хэрэг	16,881.50	46,180.13
210402	Тээвэр, шатахуун	65,221.02	124,329.87
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,779.34	6,745.52
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,582.00	14,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,553.24	111,663.54
210408	Бараа материал акталсны зардал	1,315.00	-
210409	Бараа материал шилжүүлсний зардал	1,386,348.21	1,240,918.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,188.41	73,092.25
210604	Урсгал засвар	40,188.41	73,092.25
2107	Томилолт, зочны зардал	19,359.00	38,526.00
210702	Дотоод албан томилолт	19,359.00	38,526.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	319,513.33	991,019.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,004.16	767,986.86
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	189,817.17	213,119.47
210813	Бусад зардал /ТӨҮГ/	6,692.00	9,913.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,442,493.97	3,913,880.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,185.50	2,448,586.34

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,602.19	15,306.86
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,305,706.29	1,449,987.01
212	ТАТААС	20,000.00	20,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000.00	20,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000.00	20,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,513,854.29	27,885,943.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,181,855.20	27,666,355.50
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,181,855.20	27,666,355.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,299.44	211,591.64
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,552.98	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22,445.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,746.46	189,146.04
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,269,699.65	7,996.52
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	3,638,018.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	631,544.68	-
213404	Хөрөнгийн	-	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	136.97	7,996.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,056,324.13	6,083,120.73
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,181,809.49	5,907.60
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	554.17	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	4,665.60
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	8,991,021.60	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	190,233.72	1,242.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(6,125,485.36)	6,077,213.13

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,850,576.36	1,912,473.02	9,643,283.72	19,406,333.11
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,186,916.70	652,411.19	6,647,243.15	13,486,571.04
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,186,916.70	652,411.19	12,772,728.51	19,612,056.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,663,659.66)	(1,260,061.83)	3,129,444.79	205,723.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(6,125,485.36)	(6,125,485.36)
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,186,916.70	652,411.19	6,647,243.15	13,486,571.04
2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,186,916.70	652,411.19	12,760,404.28	19,599,732.17
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,186,916.70	652,411.19	6,686,755.97	13,526,083.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	39,512.82	39,512.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(3,564.83)	(3,564.83)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	6,077,213.13	6,077,213.13

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	15,926,534,962.74	41,366,149,158.55
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,246,834,543.37	36,159,943,683.77
110	Орлогын албан татвар	3,427,738,562.68	30,753,052,644.48
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,452,711,825.61	30,798,044,514.06
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	3,270,058,606.34	10,286,854,606.38
110002	Үйл ажиллагааны орлого	21,650,885.21	18,115,086.95
110003	Хөрөнгийн орлого	-	107,372,042.91
110004	Хөрөнгө борлуулсны орлого	34,910,192.00	16,476,000.00
110008	Шууд бус орлого	126,092,142.06	20,369,226,777.82
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(24,973,262.93)	(44,991,869.58)
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(24,973,262.93)	(44,991,869.58)
113	Хөрөнгийн албан татвар	2,147,950,903.19	2,157,461,768.36
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,121,979,694.19	2,131,449,518.36
113002	Бууны албан татвар	3,739,000.00	4,565,200.00
113004	Малд ногдуулах албан татвар	22,232,209.00	21,447,050.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,671,145,077.50	3,249,429,270.93
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	132,582,353.00	234,661,947.43
118001	Улсын тэмдэгийн хураамж	23,581,810.00	20,325,500.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	78,111,743.00	150,168,947.43
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	30,888,800.00	64,167,500.00
1181	Газрын төлбөр	2,527,999,314.00	2,998,329,977.50
118101	Газрын төлбөр	2,527,999,314.00	2,998,329,977.50
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	10,563,410.50	16,437,346.00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	10,563,410.50	16,437,346.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,354,232,055.11	2,478,181,092.78
120	Нийтлэг татварын бус орлого	1,354,232,055.11	2,478,181,092.78
120002	Хүүгийн орлого	107,641,643.02	-
120003	Торгуулийн орлого	71,991,645.20	798,092,943.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	157,933,202.87	213,780,663.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	157,933,202.87	213,780,663.00
120009	Бусад орлого	109,556,421.69	291,764,880.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	907,109,142.33	1,174,542,606.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,325,468,364.26	2,728,024,382.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,343,405,725.00	2,002,720,200.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1,343,405,725.00	2,002,720,200.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	712,499,959.00	725,304,182.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	7,788,240.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	696,043,847.00	557,367,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,322,012.00	12,411,230.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,134,100.00	147,737,262.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,269,562,680.26	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,638,018,000.00	-
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	631,544,680.26	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,752,259,882.99	34,236,951,532.03
299990	Устгал	-	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,752,259,882.99	34,236,951,532.03

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,005,442,591.94	4,634,746,541.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	699,045,808.33	1,090,039,222.87
210101	Үндсэн цалин	454,011,862.55	580,466,685.23
210102	Нэмэгдэл	51,022,036.14	199,567,558.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,643,832.27	29,385,500.00
210104	Урамшуулал	6,071,934.00	71,006,522.43
210106	Ажилчдад төлсөн /ТӨҮГ/	184,296,143.37	209,612,956.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,209,234.60	193,068,456.41
210201	Тэтгэврийн даатгал	37,860,445.58	64,056,695.47
210202	Тэтгэмжийн даатгал	4,463,236.18	7,502,660.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,605,269.59	5,895,671.03
210204	Ажилгүйдлийн даатгал	860,903.38	1,421,661.01
210205	Эрүүл мэндийн даатгал	8,632,586.66	14,248,793.68
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	84,786,793.21	99,942,975.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	457,808,810.51	184,513,679.44
210301	Гэрэл, цахилгаан	28,599,688.91	17,565,299.23
210302	Түлш, халаалт	398,401,924.80	112,225,895.10
210303	Цэвэр, бохир ус	30,699,096.80	2,517,171.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	108,100.00	52,205,314.11
2104	Хангамж, бараа материалын зардал	510,538,613.60	487,831,765.61
210401	Бичиг хэрэг	15,349,650.00	22,047,260.00
210402	Тээвэр, шатахуун	55,503,039.00	83,078,274.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,779,340.00	6,745,520.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,582,000.00	14,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,980,900.00	22,728,643.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	362,343,684.60	339,132,068.41
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,847,210.00	75,807,350.00
210604	Урсгал засвар	40,847,210.00	75,807,350.00
2107	Томилолт, зочны зардал	19,359,000.00	38,526,000.00
210702	Дотоод албан томилолт	19,359,000.00	38,526,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,030,373.61	1,316,025,396.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад, ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,824,221.00	1,157,455,427.40
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	75,476,912.53	88,237,816.73
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	63,729,240.08	70,332,152.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	841,603,541.29	1,248,934,670.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	823,647,706.29	1,233,627,813.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,955,835.00	15,306,857.00
212	ТАТААС	20,000,000.00	20,000,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000,000.00	20,000,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000,000.00	20,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,726,817,291.05	29,582,204,990.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,394,818,198.35	29,361,142,683.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,394,818,198.35	29,361,142,683.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,299,443.09	210,660,784.69
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,552,984.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22,445,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,746,459.09	188,215,184.69
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,269,699,649.61	10,401,522.72
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	3,638,018,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	631,544,680.26	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	136,969.35	10,401,522.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,174,275,079.75	7,129,197,626.52
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,637,017,862.00	2,558,808,031.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,637,017,862.00	2,558,808,031.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,637,017,862.00	2,558,808,031.00
223001	Бусад хөрөнгө	791,287,089.00	2,026,964,479.65

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	845,730,773.00	483,341,051.35
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	-	48,502,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,637,017,862.00)	(2,558,808,031.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	537,257,217.75	4,570,389,595.52
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	835,777,344.88	1,373,034,562.63
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,373,034,562.63	5,943,424,158.15
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,348,936.90	7,286,420.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,276,264.70	4,974,623.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,628,980.60	3,155,649.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	812,926.10	744,418.45
210101	Үндсэн цалин	488,394.00	444,458.87
210102	Нэмэгдэл	213,787.60	199,567.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,302.00	29,385.50
210104	Урамшуулал	86,442.50	71,006.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,617.10	93,125.48
210201	Тэтгэврийн даатгал	69,400.10	64,056.70
210202	Тэтгэмжийн даатгал	8,128.80	7,502.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,423.40	5,895.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,606.00	1,421.66
210205	Эрүүл мэндийн даатгал	16,058.80	14,248.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	645,825.40	615,284.35
210301	Гэрэл, цахилгаан	53,334.00	40,112.75
210302	Түлш, халаалт	545,445.50	541,642.05
210303	Цэвэр, бохир ус	47,045.90	33,529.55
2104	Хангамж, бараа материалын зардал	177,810.00	142,112.59
210401	Бичиг хэрэг	38,630.70	20,762.38
210402	Тээвэр, шатахуун	89,500.00	77,776.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,869.10	6,745.52
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,100.00	14,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,710.20	22,728.64
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,864.70	82,698.15
210604	Урсгал засвар	88,864.70	82,698.15
2107	Томилолт, зочны зардал	66,548.00	37,726.00
210702	Дотоод албан томилолт	66,548.00	37,726.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,275,801.60	1,180,637.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад, ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,275,801.60	1,180,637.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	459,587.70	259,646.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	435,887.70	244,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,700.00	15,306.86
212	ТАТААС	20,000.00	20,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000.00	20,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20,000.00	20,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,627,284.10	1,798,974.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,556,291.30	1,733,787.08
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,556,291.30	1,733,787.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,992.80	65,187.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,445.60	22,445.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,547.20	42,741.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,072,672.20	2,311,796.63
223001	Бусад хөрөнгө	5,072,672.20	2,311,796.63

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,348,936.90	7,521,073.79
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	2,002,720.20
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	2,002,720.20
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,355,478.10	5,304,572.93
320001	Орон нутгийн төсвөөс	8,352,757.90	5,304,572.93
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	2,002,720.20	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	993,458.80	213,780.66
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	309,000.00	213,780.66
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	684,458.80	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	684,458.83
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	919,112.61

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	725,304.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,862.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405,986.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,264.80
210101	Үндсэн цалин	12,264.80
2104	Хангамж, бараа материалын зардал	6,587.11
210401	Бичиг хэрэг	1,284.88
210402	Тээвэр, шатахуун	5,302.23
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,720.00
210604	Урсгал засвар	13,720.00
2107	Томилолт, зочны зардал	800.00
210702	Дотоод албан томилолт	800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	372,315.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	372,315.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	155,875.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,473.59
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	145,473.59
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,401.52
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,401.52
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	163,442.10
2200	Дотоод эх үүсвэрээр	163,442.10
223001	Бусад хөрөнгө	144,442.10
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	725,304.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	725,304.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,788.24
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	557,367.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,411.23
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	147,737.26
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 234,7 сая төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс, 56.7,2 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 120,7 сая төгрөгийн 7 зөрчилд 2 албан шаардлага, 0,7 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 55,8 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч ажиллаа.

Аудитаар нийт 56,7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 56,7 сая төгрөгийн алдааг залруулж ажиллалаа. Үүнд:

- Тайлант онд 23,1 сая төгрөгийн хөтөлбөр арга хэмжээний зардлын ажил гүйлгээг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэн тайлагнасан,
- Санхүү байдлын тайлангийн үнэ төлбөргүй хүлээн бараа материалын дүнг бараа материалын тодруулга тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 25,1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Суманд тогтвор суурьшилтай ажилласан төрийн албан хаагчдад 85,000,000 төгрөгийн мөнгөн дэмжлэг олгоходоо 8,5 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаж төсөвт төвлөрүүлээгүй

Аудитаар нийт 177,2 сая төгрөгийн 12 зөрчил² илэрснээс, 120,7 сая төгрөгийн 7 зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 0,7 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 55,8 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Хөтөлбөр арга хэмжээний зардлаас 0,7 сая төгрөгийн хувцас худалдан авсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Орон нутгийн нөөц хөрөнгөөс багш нарын сургалтын төлбөр, урлагийн үзлэгийн зардалд 13,3 сая төгрөг зарцуулсан,

Илрүүлэлт 2: Тайлант онд орон нутгийн нөөц хөрөнгөөс 1,6 сая төгрөгийг "Тэсийн ирээдүй" төрийн бус байгууллагын гишүүдийн эрүүл мэндийн урьдчилсан үзлэг оношилгоонд хамруулахад зарцуулсан,

Илрүүлэлт 3: орон нутгийн нөөц хөрөнгөөс 1,6 сая төгрөгийг мал, эмнэлэг, үржлийн алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэхэд зарцуулсан,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5 "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", 24 дугаар зүйлийн 24.7 "*Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно*", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 "*урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 4: Сумын ИТХ-ын 2023 оны 13/07 тоот тогтоолоор төсөл хөтөлбөрт 326,2 сая төгрөг зарцуулахаар баталсан боловч хэрхэн хэрэгжүүлэх талаар боловсруулсан журам, төлөвлөгөө, хөтөлбөр, төсвийн тооцоололгүйгээр зарцуулсан,

Илрүүлэлт 5: Тайлант онд хөтөлбөр арга хэмжээний зардлаас мал, эмнэлэг, үржлийн алба үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэхэд 7,4 сая төгрөг, Засаг даргын нэрэмжит гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулахад 5,4 сая төгрөг, малчдын зөвлөгөөний зардалд 5,0 сая төгрөгийг тус тус зарцуулсан,

Илрүүлэлт 6: Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас сумын төрийн албан хаагчдад өргөмжлөлийн дагалдах мөнгөн урамшуулал 1,1 сая төгрөг олгосон,

Илрүүлэлт 7: Хөтөлбөрийн арга хэмжээний зардлаас суманд тогтвор суурьшилтай ажилласан төрийн албан хаагчдад 85,0 сая төгрөгийн нэг удаагийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дугаар зүйлийн 24.7 "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 "сум, баг, тосгон дахь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс олгох" заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсвийн бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг хангаж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн нөөц хөрөнгөөр санхүүжүүлсэн ажил гүйлгээнд төлөвлөгөө, хөтөлбөр, төсвийн тооцоолол байхгүй байна.

Илрүүлэлт 2: Орон нутгийн нөөц хөрөнгөөр санхүүжүүлсэн ажил гүйлгээнд төлөвлөгөө, хөтөлбөр, төсвийн тооцоолол байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.4 "арга хэмжээг

хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг зөв, бодитой тооцсон эсэхийг холбогдох норм, норматив, тариф, бусад баримтаар нотолсон байх", 3.1.5 "хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шийдвэрийн төсөлд хавсаргасан байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтад заасны дагуу холбогдох баримт материалыг бүрдүүлэн хавсаргаж хэвших.

Илрүүлэлт 3: Хөтөлбөр арга хэмжээний зардлаас хилийн цэргийн 0166 дугаар ангийн өрөөний тохижилт, засвар үйлчилгээнд 46,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлтийн оновчтой төлөвлөх, хөтөлбөр арга хэмжээний зардлаас хөрөнгө оруулалтын шинжтэй зарлага санхүүжилт гаргахгүй байх.

Илрүүлэлт 4: Тайлант онд хөтөлбөр арга хэмжээний зардлаас суралцаж байгаа 3 төрийн албан хаагчдын сургалтын төлбөрт 8,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зайлшгүй шаардлагатай боловсон хүчнийг мэргэшүүлэхээс бусад ахисан түвшний сургалтын төлбөрт төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх, зөрчлийг арилгаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								